



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/213

Борхойн тал

Газар эзэмшүүлэх цахим дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/11 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07/34 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус сумын нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Байгууллага, иргэдэд цахим дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохих журмын дагуу бэлтгэн зохион байгуулахыг Газрын даамал (Ж.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.


4.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.САЙНБАЯР

Сумын Засаг даргын 2026
оны 05 дугаар сарын 20 өдрийн
9/213 дугаар захирамжийн хавсралт



НИЙТИЙН ЦАХИМ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

Д/ Д	Төлөвлөл тийн нэгж талбар	Газрын байршил	Газрын зориулалт	Газрын хэмжээ м.кв	Анхны үнэ /төгрөг/	Дэнчин /төгрөг/
1.	4941316	Соёмбо баг, хил хамгаалах 0108-р ангийн урд талд	2111: худалдаа үйлчилгээний газар /бохирын шугам олоолсон шороо зайлуулах/	4000	24 000 000	2 400 000
2.	5099572	Жаргалант баг, Ложистикийн төвийн зүүн талд	2127: Терминал /ачиж буулгах талбай/	100000	240 000 000	24 000 000
3.	4876901	Жаргалант баг улаан хонхорын хойд талд	2503: Аялал жуулчлалын бааз	20000	48 000 000	4 800 000
4.	4871224	Жаргалант баг 4-р сургуулийн урд талд	2201: 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	5000	12 000 000	1 200 000
5	5140764	Жаргалант баг, Ложистикийн төвийн хойд талд	2125: Агуулах агуулахын байгууламж	66000	158 400 000	15 840 000
6	5140644	Сүлд баг Цагаан дөрвөлжийн зүүн талд	2702: авто машины зогсоол	515	3 090 000	309 000
7	5140645	Соёмбо баг Хил хамгаалах 0108-р ангийн урд талд	2111: Худалдаа үйлчилгээ	1100	6 600 000	660 000

--oOo--